

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/59/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Н.Бүнчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsuren@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2.1 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Албан шаардлага	17
4.2 Төлбөрийн акт	17
4.2 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

ЖАРГАЛАНТ СУМЫН ЗДТГ-ЫН
ДАРГА Б.ӨНӨРБАЯР ТАНАА

№ 2/112

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалант сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	88,106,598.00	102,962,983.00
33	АВЛАГА	25,994.00	330,739.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	25,994.00	00.00
335	Бусад авлага	00.00	330,739.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	330,739.00
35	БАРАА МАТЕРИАЛ	88,080,604.00	102,632,244.00
354	Хангамжийн материал	56,068,124.00	71,243,764.00
35410	Бичиг хэргийн материал	1,448,479.00	1,504,989.00
35420	Аж ахуйн материал	38,033,985.00	45,417,335.00
35450	Барилгын засварын материал	727,400.00	728,200.00
35460	Хүнсний материал	00.00	590,000.00
35470	Бусад хангамжийн материал	15,858,260.00	23,003,240.00
35600	Мал амьтад	32,012,480.00	31,388,480.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,240,571,676.61	1,189,936,584.45
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,240,571,676.61	1,189,936,584.45
392	Биет хөрөнгө	1,139,259,676.61	1,088,624,584.45
39201	Барилга, байгууламж, орон сууц	761,673,169.15	741,478,669.15
39202	Хуримтлагдсан элэгдэл	-107,560,490.11	-125,933,586.67
39203	Авто-тээврийн хэрэгсэл	206,120,800.00	221,030,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-128,838,046.41	-127,307,673.36
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	161,782,621.13	195,796,911.13
39206	Хуримтлагдсан элэгдэл	-110,650,370.24	-130,275,526.87
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55,981,750.00	56,466,750.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-40,915,216.70	-43,724,625.56
39209	Зам, гүүрийн байгууламж	194,620,000.00	194,620,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-72,428,000.26	-84,959,000.26
39214	Бусад үндсэн хөрөнгө	403,246,130.00	403,246,130.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-183,772,669.95	-211,814,263.11
393	Биет бус хөрөнгө	101,312,000.00	101,312,000.00
39301	Програм хангамж	200,000.00	200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-200,000.00	-200,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	101,312,000.00	101,312,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,328,678,274.61	1,292,899,567.45
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,073.00	29,851.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,073.00	29,851.00
413	Өглөг	3,073.00	29,851.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	3,060.00	26,804.00
4136	Бусад өглөг	13.00	13.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	13.00	13.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,328,675,201.61	1,292,869,716.45
51	Засгийн газрын хувь оролцоо	1,328,675,201.61	1,292,869,716.45
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	545,016,013.96	545,016,013.96
51101	Өмч: - төрийн	545,016,013.96	545,016,013.96
512	Хуримтлагдсан үр дүн	691,386,905.17	655,581,420.01
51210	Өмнөх үеийн үр дүн	691,386,905.17	691,386,905.17
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-35,805,485.16
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	92,272,282.48	92,272,282.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,328,678,274.61	1,292,899,567.45

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төгрөгөөр	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	532,882,162.74	587,900,519.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	153,631,970.00	107,968,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	153,631,970.00	107,968,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	153,631,970.00	1,355,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,285,400.00	1,355,800.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	151,346,570.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	00.00	61,844,500.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	00.00	44,768,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	379,250,192.74	479,932,219.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,926,492.74	35,224,319.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,894,669.00	14,160,655.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,031,823.74	21,063,664.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	368,323,700.00	444,707,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	368,323,700.00	444,707,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	548,937,869.97	623,706,004.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	548,937,869.97	623,706,004.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	530,762,786.42	552,635,871.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	206,936,019.00	213,441,188.00
210101	Үндсэн цалин	206,936,019.00	196,868,603.00
210102	Нэмэгдэл	00.00	16,572,585.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,418,344.19	27,754,746.00
210201	Тэтгэврийн даатгал	17,593,807.19	19,200,293.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,206,084.00	2,138,613.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,598,423.00	1,710,890.00
210204	Ажилгүйдлийн даатгал	417,444.00	427,724.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,602,586.00	4,277,226.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,243,314.00	51,760,721.00
210301	Гэрэл, цахилгаан	6,265,314.00	4,771,421.00
210302	Түлш, халаалт	46,978,000.00	46,989,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,409,660.00	41,173,840.00
210401	Бичиг хэрэг	4,224,660.00	3,713,590.00
210402	Тээвэр, шатахуун	22,477,520.00	35,244,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,138,000.00	778,400.00
210404	Ном, хэвлэл	156,500.00	349,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	811,800.00	1,087,900.00
210408	Бараа материал акталсны зардал	5,601,180.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	00.00	2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,342,000.00	3,124,000.00
210702	Дотоод албан томилолт	1,342,000.00	3,124,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,622,943.00	28,678,444.00

**Жаргалант сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,020,743.00	22,924,944.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	17,000.00	18,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	318,200.00	40,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,267,000.00	5,195,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	185,790,506.23	184,702,932.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,512,480.00	64,538,550.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200,000.00	130,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	141,078,026.23	120,034,382.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,175,083.55	71,070,133.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,140,000.00	46,701,661.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	37,285,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,140,000.00	9,416,561.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,035,083.55	24,368,472.50
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,459,419.81	14,116,621.00
213404	Хөрөнгийн	2,575,663.74	10,251,851.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-16,055,707.23	-35,805,485.16
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-16,055,707.23	-35,805,485.16

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	381,535,593.00	481,288,019.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,285,400.00	1,355,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,285,400.00	1,355,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,285,400.00	1,355,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,285,400.00	1,355,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	379,250,193.00	479,932,219.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,926,493.00	35,224,319.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,676,999.00	14,160,655.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,249,494.00	21,063,664.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	368,323,700.00	444,707,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	368,323,700.00	444,707,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	381,535,593.00	473,733,229.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	381,535,593.00	473,733,229.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	363,360,509.19	402,663,096.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	207,330,495.00	213,363,038.00
210101	Үндсэн цалин	164,127,695.00	177,542,555.94
210102	Нэмэгдэл	43,202,800.00	35,820,482.06
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,071,727.19	28,110,850.00
210201	Тэтгэврийн даатгал	17,696,972.19	19,478,650.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,092,528.00	2,145,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,675,500.00	1,729,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	418,127.00	432,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,188,600.00	4,324,800.00

**Жаргалант сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,214,114.00	51,171,421.00
210301	Гэрэл, цахилгаан	6,236,114.00	4,771,421.00
210302	Түлш, халаалт	46,978,000.00	46,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,027,940.00	23,064,550.00
210401	Бичиг хэрэг	4,347,550.00	3,326,100.00
210402	Тээвэр, шатахуун	23,135,900.00	17,957,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,138,000.00	831,400.00
210404	Ном, хэвлэл	156,500.00	349,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,249,990.00	599,900.00
2105	Нормативт зардал	340,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	340,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	200,000.00	2,139,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200,000.00	00.00
210604	Урсгал засвар	00.00	2,139,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,342,000.00	3,124,000.00
210702	Дотоод албан томилолт	1,342,000.00	3,124,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,727,263.00	38,873,764.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,125,063.00	33,120,264.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	17,000.00	18,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	21,200.00	40,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	5,195,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,106,970.00	42,816,473.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,106,970.00	42,816,473.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,175,083.81	71,070,133.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,140,000.00	46,701,661.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	37,285,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,140,000.00	9,416,561.00
2134	Орон нутгийн төсвийн өрөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,035,083.81	24,368,472.50
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,459,419.81	14,116,621.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,575,664.00	10,251,851.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	7,554,790.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	7,554,790.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	7,554,790.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	7,554,790.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	7,554,790.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-7,554,790.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
-----	----------	---------------------------------	-----------------------	-------------------	---

**Жаргалант сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	545,016,013.96	92,272,282.48	707,442,612.40	1,344,730,908.84
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	545,016,013.96	92,272,282.48	707,442,612.40	1,344,730,908.84
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-16,055,707.23	-16,055,707.23
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	545,016,013.96	92,272,282.48	691,386,905.17	1,328,675,201.61
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	545,016,013.96	92,272,282.48	691,386,905.17	1,328,675,201.61
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	545,016,013.96	92,272,282.48	691,386,905.17	1,328,675,201.61
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-35,805,485.16	-35,805,485.16
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	545,016,013.96	92,272,282.48	655,581,420.01	1,292,869,716.45

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	445,708,000.00	431,947,079.00	13,760,921.00	96.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	445,708,000.00	431,947,079.00	13,760,921.00	96.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	399,005,900.00	385,245,418.00	13,760,482.00	96.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	216,257,100.00	213,363,038.00	2,894,062.00	98.66
210101	Үндсэн цалин	180,171,500.00	177,542,555.94	2,628,944.06	98.54
210102	Нэмэгдэл	36,085,600.00	35,820,482.06	265,117.94	99.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,175,000.00	28,110,850.00	1,064,150.00	96.35
210201	Тэтгэврийн даатгал	20,542,800.00	19,478,650.00	1,064,150.00	94.82
210202	Тэтгэмжийн даатгал	2,145,000.00	2,145,000.00	00.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,729,900.00	1,729,900.00	00.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	432,500.00	432,500.00	00.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,324,800.00	4,324,800.00	00.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,449,700.00	51,171,421.00	1,278,279.00	97.56
210301	Гэрэл, цахилгаан	5,892,300.00	4,771,421.00	1,120,879.00	80.98
210302	Түлш, халаалт	46,557,400.00	46,400,000.00	157,400.00	99.66

**Жаргалант сумын ЭДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2104	Хангамж, бараа материалын зардал	24,831,800.00	23,064,550.00	1,767,250.00	92.88
210401	Бичиг хэрэг	3,326,700.00	3,326,100.00	600.00	99.98
210402	Тээвэр, шатахуун	19,710,000.00	17,957,850.00	1,752,150.00	91.11
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	835,100.00	831,400.00	3,700.00	99.56
210404	Ном, хэвлэл	360,000.00	349,300.00	10,700.00	97.03
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	599,900.00	100.00	99.98
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,694,800.00	9,693,790.00	1,010.00	99.99
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,500,000.00	7,499,790.00	210.00	100.00
210604	Урсгал засвар	2,194,800.00	2,194,000.00	800.00	99.96
2107	Томилолт, зочны зардал	4,395,500.00	3,124,000.00	1,271,500.00	71.07
210702	Дотоод албан томилолт	4,395,500.00	3,124,000.00	1,271,500.00	71.07
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,722,000.00	13,901,296.00	1,820,704.00	88.42
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,600,000.00	8,147,796.00	1,452,204.00	84.87
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00	00.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	18,000.00	18,000.00	00.00	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	40,000.00	00.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,564,000.00	5,195,500.00	368,500.00	93.38
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46480000.00	42816473.00	3,663,527.00	92.12
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,480,000.00	42,816,473.00	3,663,527.00	92.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46702100.00	46701661.00	439.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,702,100.00	46,701,661.00	439.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,285,100.00	37,285,100.00	00.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,417,000.00	9,416,561.00	439.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	445,707,900.00	431,947,079.00	13,760,821.00	96.91
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	444,707,900.00	430,591,279.00	14,116,621.00	96.83
132001	Орон нутгийн төсвөөс	444,707,900.00	430,591,279.00	14,116,621.00	96.83
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	1,355,800.00	-355,800.00	135.58
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,355,800.00	-355,800.00	135.58
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	20	20	00.00	100.00
620001	Удирдах ажилтан	7	7	00.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	7	7	00.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	6	6	00.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,350,829.00	24,972,468.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,350,829.00	24,972,468.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,350,829.00	24,972,468.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,350,829.00	24,972,468.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,350,829.00	24,972,468.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,350,829.00	24,972,468.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,894,669.00	14,138,168.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,456,160.00	10,834,300.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Жаргалант сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Жаргалант сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022-ны 01 дүгээр сарын 24 өдрийн 2/09 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Жаргалант сумын ЗДТГ-ын Б.Өнөрбаяр, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Д.Баттөр нар зурж байна.

3.2.1 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Жаргалант сумын ЗДТГ нь “Төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг оновчтой зохион байгуулж, мэргэшсэн төрийн албан хаагчдаар төрийн албыг бүрдүүлэн иргэдэд төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, тэгш хүртээмжтэй хүргэж, сумын хөгжилд дэмжлэг үзүүлэх” эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүү хяналт, аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Жаргалант сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 548,937.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,234.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,763.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход гүйцэтгэлийн материаллаг байдал 6,548.9 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Жаргалант сумын ЗДТГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1,292,899.6 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 35,778.7 мянган төгрөгөөр буюу 2.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	88,106.6	102,963.0	14,856.4
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	26.0	330.7	304.7
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	88,080.6	102,632.2	14,551.6
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,240,571.7	1,189,936.6	(50,635.1)
Үндсэн хөрөнгө	1,884,936.5	1,914,151.3	29,214.8
Хуримтлагдсан элэгдэл	(644,364.8)	(724,214.7)	(79,849.9)
Нийт хөрөнгө	1,328,678.3	1,292,899.6	(35,778.7)
Өр төлбөр	3.1	29.9	26.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,328,675.2	1,292,869.7	(35,805.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,328,678.3	1,292,899.6	(35,778.7)

/Эх сурвалж: Жаргалант сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлангаас/

Авлагын дансны 330.7 мянган төгрөг болж 304.7 мянган төгрөгөөр өссөн нь бусад зардлын тооцооны авлага 330.7 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Энэ авлага нь Захиргааны хэргийн анхан шатны 2021.01.27-ны өдрийн 111/ШШ2021/0004 шүүхийн шийдвэрээр сургуулийн захирал Б.Саранцэцэг ажилд эргүүлж томилж ажилгүй байсан хугацааны цалин НДШ олгох шийдвэр гарсны дагуу, ажилгүй Аудитын код БНА-2022/59/НА-СТА-ТШЗ

байсан хугацааны цалинд 3,481.5 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийн зардлаас олгож зардлаар тайлагнасан ба 2020 оны 9-12 сарын НДШ-д 330.7 мянган төгрөгийг 2021.12.01-нд Нийгмийн даатгалын хэлтэст шилжүүлж авлагаар бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 102,632.2 мянган төгрөг болж 14,551.6 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материал 56.5 мянга, аж ахуйн материал 7,383.4 мянга, хүнсний материал 590.0 мянга, бусад хангамжийн материал 7,145.0 төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна. Мөн тайлант онд аймгийн Онцгой байдлын газраас 12,800.0 мянган төгрөгийн ариутгалын бодис болон нэг удаагийн хамгаалах хэрэгсэл, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 29,401.0 мянган төгрөгийн өвс тэжээл, Онцгой байдлын Ерөнхий газраас 1,550.0 мянган төгрөгийн өвс нийт 35,363.0 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,914,151.3 мянган төгрөг болж 29,214.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 7,554.8 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, 34,900.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 19,800.0 мянган төгрөгийн утасны сүлжээ цэнэглэгчийг Орон нутгийн сангийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэж үнэ төлбөргүй шилжүүлэн авсан, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021.12.14-ны өдрийн 137 дүгээр тогтоолоор 20,194.5 мянган төгрөгийн бэлчээр хашсан талбайг данснаас хассан, Аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2018.10.26-ны өдрийн А/309 тоот албан бичгийн дагуу 19,990.0 мянга төгрөгийн өртөгтэй фургон автомашиныг дуудлага худалдаа зохион байгуулж худалдсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,292,899.6 мянган төгрөг болж 35,805.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 35,805.5 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 556,437.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 556,437.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 158,450.8 мянган төгрөгөөр бууруулж 397,986.5 мянган төгрөгөөр анх батлагдсан ба төсвийн тодотголоор 47,721.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн цалин, НДШ, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, томилолт зочны зардал, бараа үйлчилгээний зардлыг нэмэгдүүлэн баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 445,708.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 444,707.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 444,707.9 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 1,355.8 мянган төгрөгийн орлого орж, урсгал үйл ажиллагаанд 431,947.1 мянган төгрөгийг зарцуулж орон нутгийн төсвийн санхүүжилтээс 14,116.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 431,947.1 мянган төгрөг буюу 96.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлаас 2,894.1 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 1,064.1 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,278.3 мянга, хангамж бараа материалын зардал 1,767.3 мянга, дотоод албан томилолт 1,271.5 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 1,820.7 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 3,663.5 мянган төгрөг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 35,224.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 24,972.5 мянган төгрөг зарцуулж 10,251.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Үүнд дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөнд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс малчдад өвс хүргэх зардалд 3,385.2 мянга, аймгийн Статистикийн хэлтсээс мал тооллогын зардалд 903.5 мянга, аймгийн ХХААГ-аас оготно устгалын зардалд 9,072.0 мянга, аймгийн ГБХЗХГ-аас хамтарсан багийн санхүүжилт 800.0 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогын дансанд ард иргэдээс хандив 12,270.0 мянга, аймгийн Эрчим хүчний газраас хог хаягдлын хураамж 170.0 мянга, ёнкосны төлбөрт иргэнээс 3,000.0 мянга, Чандмань Баянхонгор ХК-аас усны төлбөрт 3,048.0 мянга, урд оны үлдэгдэл 2,575.7 мянга нийт 35,224.3 мянган төгрөгийн орлого төвлөрч 24,972.5 мянган төгрөгийг зарцуулж 10,251.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитор М.Алтантуяа аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 74 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 86 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 623,706.0 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 74,768.1 мянган төгрөгөөр буюу 13.6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл хангамж, бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, томилолт, зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, урсгал шилжүүлгийн зардал өмнөх оноос өсөж, байр ашиглалттай тогтмол зардал, бараа үйлчилгээний бусад зардал өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

Мөн тайлант хугацаанд шүүхийн шийдвэрийн дагуу нэг удаагийн урамшууллын зардлаас 3516.5 мянган төгрөг, НДШ-ийн зардлаас 330.7 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 493,474.0 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр) 11 сарын 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан ба Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 24 гүйлгээний 376,041.4 мянга, зарлагын 2 гүйлгээний 37,285.1 төгрөгийг мэдээлээгүй байна. Энэ нь шилэн дансны

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9	0	2
2	Хагас жил	4	4	4	0	
3	Улирал бүр	1	4	4	0	
4	Сар бүр	3	36	36	0	
5	Тухай бүр	8	96	95	1	
	Нийт	27	151	148	1	2

хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор

мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.9.2 Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Тайлант онд нийт 431,947.1 мянган төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 431,947.1 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 14,166.6 мянган төгрөг буюу төсвийн 3.2 хувийг буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 54,723.3 мянган төгрөгөөр, тодотголоор 2,273.6 мянган төгрөгөөр бууруулж оны эцэст 51,171.4 мянган төгрөгийг зарцуулсан нь ЗГ-ын 43 тогтоолын 1.8 дах заалттай нийцэж байна.

3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан ба 28745.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 28745.5 мянган төгрөгийн зөрчил арилгуулах 3 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг 2021.10.05-ны өдрийн 2/92 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна.

Мөн Аймгийн Засаг даргын 2020 оны А/101 тоот “Дутагдсан болон маргаантай хөрөнгийн талаар авах арга хэмжээний тухай” захирамжаар 2500.0 мянган төгрөгийн хүлэмж дутагдсан тул буруутай этгээдээр төлүүлэх” албан шаардлага өгсөн боловч одоо болтол хэрэгжээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Саранцэцэг нь аймгийн Засаг даргын 2019.12.30-ний өдрийн Б/684 тоот захирамжаар захирлын үүргийг түүр орлон гүйцэтгэгчээр томилогдон ажиллаж байгаад 2020.07.01-ээс “Боловсролын тухай хууль”-ийн 31 дүгээр зүйлд орсон өөрчлөлтийг дагаж мөрдөх болсонтой холбоотойгоор аймгийн Засаг даргын 2020.07.01-ний өдрийн Б/09 тоот захирамжаар аймгийн хэмжээний бүх сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарыг чөлөөлөхөд хамт чөлөөлөгдсөн байна.

Тус хуулийн өөрчлөлтийн дагуу сумдын засаг дарга нар сургууль, цэцэрлэгийн захирлыг томилохоор болж 2020.07.01-ний өдрөөс эргүүлэн томилохоор байхад Жаргалант сумын Засаг дарга Д.Сайнбилэг аймгийн засаг даргын 2020.07.01-ний өдрийн Б/09 тоот захирамжийн 2 дугаар заалтын дагуу эргүүлэн томилоогүй бөгөөд 2020.07.31-ний өдрийн А/100 дугаар захирамжаар сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр өөр хүнийг томилсон байна.

Дээрх захирамжийг үндэслэлгүй гэж үзэн Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хандсан ба Баянхонгор аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны 2021.01.27-ны өдрийн 111/ШШ2021/0004 шүүхийн шийдвэрээр ажилд эргүүлж томилж ажилгүй байсан хугацааны цалинг олгох шийдвэр гарсны дагуу 2021.08.03-ны өдөр нэг удаагийн тэтгэмжийн зардлаас 3516.5 мянга, 2020 оны 9-12 сарын НДШ-д 330.7 мянга нийт 3,847.2 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Иймд төрд учруулсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 420518.7 мянган төгрөгийн 4 зөрчил илэрч 810.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 3,847.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 415,861.5 мянган төгрөгийн алдаа зөрчил давтан гаргахгүй 2 зөвлөмжийг хүргүүлээ.

4.1 Албан шаардлага

Сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Саранцэцэгийг аймгийн Засаг даргын 2020.07.01-ны өдрийн Б/09 дугаар захирамжаар Боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлд өөрчлөлт орсны дагуу ажлаас халагдаж эргүүлэн сумын Засаг дарга ажилд томилохоор байхад томилоогүй тул шүүхэд хандсан байна.

Баянхонгор аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны 2021.01.27-ны өдрийн 111/ШШ2021/0004 шүүхийн шийдвэрээр ажилд эргүүлж томилж ажилгүй байсан хугацааны цалинг олгох шийдвэр гарсны дагуу 2021.08.03-ны өдөр нэг удаагийн тэтгэмжийн зардлаас 3516.5 мянга, 2020 оны 9-12 сарын НДШ-д 330.7 мянга нийт 3,847.2 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төрийн албан хаагчийн буруутай үйлдлийн улмаас төрд учруулсан 3,847.2 мянган төгрөгийн хохирлыг хуулийн дагуу шийдвэрлүүлэх арга хэмжээ авах албан шаардлага өгөв.

4.2 Төлбөрийн акт

1. ЗДТГ-ын босоо удирдлагатай нийгмийн даатгалын байцаагч, татварын байцаагч, байгаль хамгаалагч нарт 2021 оны эхний хагас жилийн үр дүн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг харгалзан сумын ЗДТГ-ын даргын 2021.08.02-ны өдрийн А/25 дугаар тушаалаар нэг удаагийн тэтгэмжийн зардлаас 810.0 мянган төгрөгийг олгож зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт", "Нийцсэн бөгөөд зохистой байх" байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Холбогдох албан тушаалтнуудаар 810.0 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Тус байгууллага нь 2021 онд нийт 493,474.0 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр) 11 сарын 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан ба Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 24 гүйлгээний 376,041.4 мянга, зарлагын 2 гүйлгээний 37,285.1 төгрөгийг мэдээлээгүй байна

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4 " Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг бүрэн, үнэн зөв мэдээлж байх.

2. Сумын Засаг даргын А/130 дугаар захирамжаар Монгол орны үзэсгэлэнт байгаль, түүхэн дурсгалт төслийн хүрээнд зураг авалт, баримтат кино хийх хамтран ажиллах гэрээг хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд 2021.09.29-нд "Титанс Пикчерс" ХХК-д 2,535.0 мянган төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2021.04.20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам", Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.1-т "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулахдаа Сангийн сайдын 2021.04.20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам" болон Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
				Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Жаргалант сумын ЗДТГ	4	420,518.7			1	810.0	1	3,847.2	2	415,861.5

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

оОо